ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Амгалан мэргэжлийн боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/087/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Долгорсүрэн<br>Утас:261628 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn<br>Аудитор Ж.Мөнхтуул<br>Утас:261740 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn<br>Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн<br>Ахлах аудитор/аудитор: Г.Рэвгээсүрэн<br>Утас: 77270808<br>Цахим хаяг:Revgeesuren.2017@gmail.com<br>Захирал:Ш.Ичинхорлоо<br>Утас: 77270808<br>Цахим хаяг:ichinkhorloo2023@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/813
танай ____________-ны №____________-т

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АМГАЛАН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ДЭД ХУРАНДАА Х.БАТБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

дагуу ШШГЕГ-ын Амгалан мэргэжлийн боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант хугацаанд Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хууль шинэчлэн батлагдсаны дагуу ШШГЕГ-ын даргын 2024 оны А/16 дугаар тушаалаар тус Сургалт-үйлдвэрлэлийн төвийн нэршлийг “Амгалан” мэргэжлийн боловсролын сургууль болгон өөрчилсөн байна. Амгалан мэргэжлийн боловсролын сургууль нь 2024 онд 4 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөсөн байна. Төлөвлөсөн ажлын хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

**Аудитын гол асуудал**

ШШГЕГ-ын Амгалан мэргэжлийн боловсролын сургууль үйл ажиллагааны чиглэлийн дагуу мэргэжлийн боловсрол олгох сургалтад 202, мэргэжлийн сургалтад 700, нийт 902 суралцагчийг хамруулан амжилттай төгсгөж, мэргэжлийн үнэмлэх болон чадамжийн гэрчилгээг олгохын зэрэгцээ 2 дүүргийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-с хэрэгжүүлж буй мэргэжил олгох сургалтад 58 хоригдлыг хамруулан гуталчин, оёдолчин мэргэжлээр төгсгөж, чадамжийн гэрчилгээ олгосон байна.

Z:\Yawsan_Bichig\2025\0225 SNAG-115.Docx

1525300465

**Бусад асуудлын хэсэг**

ШШГЕГ-ын Амгалан мэргэжлийн боловсролын сургуулийн мэргэжлийн багш нар ШШГЕГ-ын бүх хорих ангиудын эрх нь хязгаарлагдсан, хорих ял эдэлж буй хүмүүст төрөл бүрийн мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах ажлыг гүйцэтгэдэг байна. Тус ангийн үндсэн үйл ажиллагааг голлон гүйцэтгэж буй мэргэжлийн багш нарт олгох албан томилолтын зардлыг нь бодит тооцоо судалгаагүйгээр хасаж, олгохгүй байгаа нь тус байгууллага үндсэн ажиллагаагаа хэрэгжүүлэх болон дээд шатны байгууллага болох ХДХЯ, ШШГЕГ зэрэг байгууллагуудын тайлант оны зорилтот түвшин хэрэгжихгүй байх, сургалтын үйл ажиллагааг чанартай, хүрэлцээтэй байдлаар зохион байгуулахад сөргөөр нөлөөлж байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

ATA9693 9006109
9023030583

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **51,988,455.80** | **30,848,601.77** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 505,720.03 | 100,000.00 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 505,720.03 | 100,000.00 |
| **3121** | **Төгрөг** | 505,720.03 | 100,000.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 505,720.03 | 100,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 51,482,735.77 | 30,748,601.77 |
| **354** | **Хангамжийн материал** | 51,482,735.77 | 30,748,601.77 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 11,722,426.00 | 13,081,122.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 37,836,194.77 | 15,357,404.77 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 80,000.00 | 360,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,844,115.00 | 1,950,075.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **40,727,480.25** | **52,068,449.78** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 40,727,480.25 | 52,068,449.78 |
| **392** | **Биет хөрөнгө** | 39,944,980.17 | 51,317,232.38 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 16,500,000.00 | 16,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (8,249,999.94) | (13,749,999.90) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 33,178,127.00 | 54,010,544.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (16,264,197.79) | (17,477,698.62) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 22,514,936.00 | 21,883,248.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (7,733,885.10) | (9,848,861.10) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 782,500.08 | 751,217.40 |
| 39301 | Программ хангамж | 2,055,384.00 | 2,055,384.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,272,883.92) | (1,304,166.60) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **92,715,936.05** | **82,917,051.55** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **100,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 100,000.00 |
| **413** | **Өглөг** | - | 100,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 100,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 100,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **92,715,936.05** | **82,817,051.55** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 92,715,936.05 | 82,817,051.55 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 38,997,652.44 | 38,997,652.44 |
| 51101 | Өмч: - төрийн | 38,997,652.44 | 38,997,652.44 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 53,718,283.61 | 43,819,399.11 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 50,693,158.68 | 53,718,283.61 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 3,025,124.93 | (9,898,884.50) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **92,715,936.05** | **82,917,051.55** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* /төгрөгөөр/

| **Дансны код** | Үзүүлэлт | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **632,884,830.00** | **835,470,579.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,297,430.00** | **9,448,379.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,297,430.00 | 9,448,379.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,297,430.00 | 9,448,379.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6,297,430.00 | 9,448,379.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **626,587,400.00** | **826,022,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 624,587,400.00 | 821,846,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 624,587,400.00 | 821,846,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,000,000.00 | 4,176,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,000,000.00 | 4,176,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **629,859,705.07** | **845,369,463.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **629,859,705.07** | **845,369,463.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 568,671,805.07 | 787,941,722.47 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 479,899,900.00 | 674,705,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 300,212,100.00 | 325,057,500.00 |
| 210102 | Нэмэгдэл | 147,526,279.00 | 223,258,100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,114,300.00 | 86,079,600.00 |
| 210104 | Урамшуулал | 13,047,221.00 | 40,310,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 10,487,688.97 | 14,919,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 797,122.82 | 892,000.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 93,779.16 | 104,941.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 75,023.32 | 109,891.85 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,755.84 | 52,470.62 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,503,007.83 | 13,760,095.83 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,548,843.00 | 20,767,154.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 4,565,464.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,409,700.00 | 12,722,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 298,400.00 | 600,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 453,800.00 | 0.0 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,186,943.00 | 2,878,990.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 216,919.57 | - |
| 210502 | Хоол, хүнс | 216,919.57 | 0.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,304,000.00 | 4,034,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 1,034,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,304,000.00 | 3,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 12,500,000.00 | 20,520,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,500,000.00 | 20,520,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,136,091.00 | 11,770,179.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,484,400.00 | 2,120,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,000,000.00 | 5,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 179,691.00 | 177,379.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,450,000.00 | 4,450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 35,578,362.53 | 41,225,389.47 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,561,513.00 | 20,357,280.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 16,016,849.53 | 20,868,109.47 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 61,187,900.00 | 57,427,741.03 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 61,187,900.00 | 57,427,720.03 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 58,842,900.00 | 51,582,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,345,000.00 | 5,845,720.03 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 21.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 21.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **3,025,124.93** | **(9,898,884.50)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **3,025,124.93** | **(9,898,884.50)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **627,093,120.03** | **826,122,179.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **505,720.03** | **100,000.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **505,720.03** | **100,000.00** |
| 120009 | Бусад орлого | 505,720.03 | 100,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **626,587,400.00** | **826,022,179.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **624,587,400.00** | **821,846,179.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 624,587,400.00 | 821,846,179.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,000,000.00** | **4,176,000.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,000,000.00 | 4,176,000.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **626,804,319.57** | **822,254,120.03** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **626,804,319.57** | **822,254,120.03** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **565,616,419.57** | **764,826,379.00** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **480,158,400.00** | **674,705,600.00** |
| 210101 | Үндсэн цалин | 300,212,100.00 | 325,057,500.00 |
| 210102 | Нэмэгдэл | 147,784,779.00 | 223,258,100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,114,300.00 | 86,079,600.00 |
| 210104 | Урамшуулал | 13,047,221.00 | 40,310,400.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **10,675,700.00** | **14,919,400.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 797,122.82 | 892,000.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 93,779.16 | 104,941.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 75,023.32 | 109,891.85 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,755.84 | 52,470.62 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,691,018.86 | 13,760,095.83 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **11,996,400.00** | **15,382,700.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 2,160,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,742,600.00 | 12,622,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 600,000.00 | 600,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 453,800.00 | - |
| 2105 | **Нормативд зардал** | **216,919.57** | - |
| 210502 | Хоол, хүнс | 216,919.57 | - |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,757,800.00** | **4,426,100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,000,000.00 | 1,426,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 453,800.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 2,304,000.00 | 3,000,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **12,500,000.00** | **20,520,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,500,000.00 | 20,520,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,151,700.00** | **11,770,179.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,500,000.00 | 2,120,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,000,000.00 | 5,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 179,700.00 | 177,379.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,450,000.00 | 4,450,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **34,159,500.00** | **23,102,400.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 34,159,500.00 | 23,102,400.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,187,900.00** | **57,427,741.03** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **61,187,900.00** | **57,427,720.03** |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 58,842,900.00 | 51,582,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,345,000.00 | 5,845,720.03 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **21.00** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 21.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **288,800.46** | **3,868,058.97** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **1,435,500.00** | **4,273,800.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,435,500.00** | **4,273,800.00** |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | **1,435,500.00** | **4,273,800.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,435,500.00 | 4,273,800.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(1,435,500.00)** | **(4,273,800.00)** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(1,146,699.54)** | **(405,741.03)** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 216,919.57 | 505,720.03 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 505,720.03 | 100,000.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 38,997,652.44 | 50,693,158.68 | 89,690,811.12 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **38,997,652.44** | **50,693,158.68** | 89,690,811.12 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | 3,025,124.93 | 3,025,124.93 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **38,997,652.44** | **53,718,283.61** | 92,715,936.05 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **38,997,652.44** | **53,718,283.61** | 92,715,936.05 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | -9,898,884.50 | -9,898,884.50 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **38,997,652.44** | **43,819,399.11** | **82,817,051.55** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| **Дансны эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** | **Хувь** |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **821,846,200.00** | **821,846,179.00** | **21.00** | **100.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **821,846,200.00** | **821,846,179.00** | **21.00** | **100.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **764,924,200.00** | **764,924,179.00** | **21.00** | **100.0** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **674,705,600.00** | **674,705,600.00** | **-** | **100.0** |
| 210101 | Үндсэн цалин | 325,057,500.00 | 325,057,500.00 | - | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 223,258,100.00 | 223,258,100.00 | - | 100.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 86,079,600.00 | 86,079,600.00 | - | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 40,310,400.00 | 40,310,400.00 | - | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,919,400.00** | **14,919,400.00** | **-** | **100.0** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,919,400.00 | 14,919,400.00 | - | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **15,382,700.00** | **15,382,700.00** | **-** | **100.0** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,160,000.00 | 2,160,000.00 | - | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,622,700.00 | 12,622,700.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 600,000.00 | 600,000.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,000,000.00** | **6,000,000.00** | **-** | **100.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 20,520,000.00 | 20,520,000.00 | - | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,520,000.00 | 20,520,000.00 | - | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,770,200.00** | **11,770,179.00** | **21.00** | **100.0** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,120,800.00 | 2,120,800.00 | - | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 177,400.00 | 177,379.00 | 21.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,450,000.00 | 4,450,000.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **21,626,300.00** | **21,626,300.00** | **-** | **100.0** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 21,626,300.00 | 21,626,300.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **56,922,000.00** | **56,922,000.00** | **-** | **100.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **56,922,000.00** | **56,922,000.00** | **-** | **100.0** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 51,582,000.00 | 51,582,000.00 | - | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,340,000.00 | 5,340,000.00 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **821,846,200.00** | **821,846,221.00** | **(21.00)** | **100.0** |
| **1310** | **Улсын төсвөөс санхүүжих** | **821,846,200.00** | **821,846,221.00** | **(21.00)** | **100.0** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 821,846,200.00 | 821,846,221.00 | (21.00) | 100.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 505,720.03 | 505,720.03 | - | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 100,000.00 | (100,000.00) | |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1. Аудитаар нийт 7,405.9 мянган төгрөгийн 1 зөрчлийг илрүүлж, зардлын эдийн засгийн ангиллыг буруу ангилан бүртгэж, тайлагнасантай холбоотой 7,405.9 мянган төгрөгийн 1 зөрчилд зөрчлийг засах, дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж[1] өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Зардлын эдийн засгийн ангиллыг зөв ангилан бүртгэж толилуулах | 1 | 7,405.9 | | 0.0 | | 0.0 | 1 | 7,405.9 | | 0.0 | | 0.0 |
| | Дүн | 1 | 7,405.9 | | 0.0 | | 0.0 | 1 | 7,405.9 | | 0.0 | | 0.0 |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/